Цагдаагийн ерөнхий газрын даргын
2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
А/401 дугаар тушаалын хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:**

☑ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2023.12.27

**Байгууллагын нэр:**

Цагдаагийн ерөнхий газар

**Нэгжийн нэр:**

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн

**Албан тушаалын нэр:**

Байцаагч

**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**

ТТ-8

**Ажлын цаг:**

8 цаг

**Албан байрны албан ёсны байршил:**

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын байр

**Хөдөлмөрийн нөхцөл:**

Хэвийн

**Онцгой нөхцөл:**

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

**Албан тушаалын зорилго:**

Цагдаагийн албаны тухай хуульд заасан олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шүүхийн барилга байгууламжийн аюулгүй байдлыг хамгаалах, шүүх хуралдааны дэг сахиулах, яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг шүүхэд албадан ирүүлэх ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, зааварчилгаа, зөвлөмж өгөх удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

**Албан тушаалын зорилт:**
1.Шүүх, шүүхийн барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах ажлыг төлөвлөх, хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.
2. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны дэг сахиулах ажлыг төлөвлөх, хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.
3. Яллагдагч, шүүгдэгчийг нэг объектоос нөгөө объектод хуяглан хүргэх, хүч нэмэгдүүлэн хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг үндэслэн яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг шүүхэд албадан ирүүлэх ажлыг төлөвлөх, хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.
4.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Харилцан гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.1. Шүүх, шүүхийн барилга, байгууламжийн судалгааг гаргаж, учирч болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр харуул, хамгаалалтын төлөвлөгөө, зураглал, алба хаагчдын эрх бүхий албан тушаалтнаар батлуулах, хамгаалалтын цагдаа, харуулын цагдааг мэргэжлийн удирдлагаар хангаж, зааварчилгаа, зөвлөмж, үүрэг даалгавар өгч, хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож удирдлагад танилцуулах;<br>1.2. Харуулын цагдаагийн ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, алба хаагчдын албаны бэлэн байдал, тусгай хэрэгсэл, дүрэмт хувцас, энгэрийн тэмдэг, албаны үнэмлэх зэргийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах;<br>1.3. Харуулын цагдаа нарын үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавьж, шалган зааварчлах. | Улсын онц чухал обьектын хамгаалалт хэвийн явагдсан байна. | Г<br>Х<br>Х |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 2.1.Шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, шүүх хуралдааны дэг сахиулах, учирч болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр хамгаалалтын төлөвлөгөө, зураглал, алба хаагчдын ажил үүргийн хуваарийг боловсруулах, мэргэжлийн удирдлагаар хангаж, зааварчилгаа, зөвлөмж, үүрэг даалгавар өгч, хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож удирдлагад танилцуулах;<br>2.2. Хамгаалалтын цагдаагийн ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, алба хаагчдын албаны бэлэн байдал, тусгай хэрэгсэл, дүрэмт хувцас, | Байгууллагын үйл ажиллагаанд үнэлнлт, дүгнэлт өгч, эрсдэл тооцогдсон байна. | Х<br>Х |

| | | | |
|---|---|---|---|
| | энгэрийн тэмдэг, албаны үнэмлэх зэргийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах;<br>2.3.Хамгаалалтын цагдаа нарын үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавьж, шалган зааварчлах.<br>2.4 Ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг цаг тухай бүрт гаргаж, мэдлэг, ур чадвар, бие бялдар, сахилга ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх. | | Х<br>Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 3.1.Хуяглан хүргэх, албадан ирүүлэх ажиллагаанд учирч болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр хамгаалалтын төлөвлөгөө, зураглалыг боловсруулж, нууцлалыг чанд хадгалж алба хаагчдын ажил үүргийн хуваарийг боловсруулах, мэргэжлийн удирдлагаар хангаж, зааварчилгаа, зөвлөмж, үүрэг даалгавар өгч, хяналт тавьж, биелэлт үр дүнг тооцож удирдлагад танилцуулах;<br>3.2. Хамгаалалтын цагдаагийн ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, алба хаагчдын албаны бэлэн байдал, тусгай хэрэгсэл, дүрэмт хувцас, энгэрийн тэмдэг, албаны үнэмлэх зэргийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах;<br>3.3.Хамгаалалтын цагдаа нарын үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавьж, шалган зааварчлах.<br>3.4.Албадан ирүүлэх захирамжид нэр дурдагдсан этгээдийн талаар мэдээлэл цуглуулах, төрийн болон холбогдох бусад байгууллагаас шаардлагатай мэдээллийг авах. | Алба хаагчдын сахилга, ёс зүй дээшилж, эрх ашиг сонирхол хангагдсан байна. | Г<br>Х<br>Г<br>Г<br>Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | **Ажлын байрны зорилтын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:**<br>1. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;<br>2. Шууд удирдах албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаварын биелэлтийг хангуулах;<br>3. Албан хэрэг хөтлөлт, архивын журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;<br>4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид иргэдтэй | Ажлын байрны зорилго, зорилт хангагдаж, цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүрэг хангагдана. | Г<br>Г<br>Г<br>Г |

| | | | |
|---|---|---|---|
| | зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх.<br>**Шударга ёсны шалгуурыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар:**<br>1. Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд сахих;<br>2. Явцуу эрх ашиг сонирхолоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах. | | Г<br>Г |

## III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

| | | |
|---|---|---|
| Боловсрол | -Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй | |
| Мэргэжил | - Эрх зүй /0421/, Аюулгүй байдал судлал /103901/, Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/. | |
| Мэргэжил | -Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх | |
| Туршлага | Цагдаагийн байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх. | |
| Ур чадвар | Дүн шилжилгээ хийх | -Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх<br>-Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах<br>-Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй |
| | Асуудал шийдвэрлэх | -Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах<br>-Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах |
| | Багаар ажиллах | -Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах<br>-Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох |
| | Бусад | -Мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар |

## IV.АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ:

| **Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:**<br>Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга | |
|---|---|
| **Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:**<br>Батлагдсан орон тоо. | **Бусад харилцах субъект:**<br>**Шууд харилцах байгууллага:**<br>Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан:<br>**Шууд бус харилцах байгууллага:**<br>Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн:<br>/Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтлана/ |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:** |
|---|---|

<table>
<tr><td>Албан тушаал:<br><br>ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН<br>ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА<br><br>Т.ГАНЗОРИГ<br><br>2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр</td><td>Байгууллагын нэр:..................<br>Шийдвэрийн огноо:.................<br>Дугаар:....................................</td></tr>
<tr><td colspan="2">Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</td></tr>
<tr><td colspan="2">Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР<br>Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27 өдөр.<br>Дугаар: А/401<br><br>ДАРГА,<br>ЦАГДААГИЙН ХУРАНДАА Т.СҮХБОЛД<br><br>2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр</td></tr>
</table>

ТАНИЛЦСАН:

| |
|---|
| Танилцсан албан тушаалтан........................................................................................................ ........................................................................................................................................................ |
| 20... оны .... дугаар сарын ....-ны өдөр |